



“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын
Даргын 2025 оны 07 дугаар сарын
23-ны өдрийн 4/52 дугаар
тушаалын хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/225 дугаар захирамжаар бүтэц шинэчлэгдсэн

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль
тогтоомжийн нэр, огноо:

Хөдөлмөрийн тухай хууль, 2021.07.02

Дагаж мөрдөх огноо: 2022.01.01

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан огноо:

2025.07.23

Байгууллагын нэр:

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ

Нэгжийн нэр:

Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэс

Ажлын байрны нэр:

Автобусны жолооч

Ажлын байрны ангилал, зэрэглэл:

Хамаарахгүй

Ажлын цаг:

Ээлжийн

Ажлын байрны албан ёсны байршил:

Тахилт-14, 33 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн бус

Онцгой нөхцөл: Хамаарахгүй

II. АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Замын хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг биелүүлж, тээврийн хэрэгсэл жолоодож батлагдсан цаг графикайн дагуу нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхэд оршино.

Ажлын байрны зорилт:

1. Байгууллагын нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг техникийн шаардлагын дагуу эзэмшин хуваарилсан чиглэл, замнал, цагийн хуваарийн дагуу зорчигчдыг ая тухтай тээвэрлэх, нийтийн тээврийн стандартын шаардлагыг биелүүлэх

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандартыг мөрдөж ажиллах, ажилтнуудын аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлөөр хангуулах

Зорилт	Ажлын байрны гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	1.1.Жолооч нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолттой танилцан хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ тус тус байгуулж, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилга, хувийн дугаар, нийтийн тээврийн газраас ID код авах	Жолооч нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолттой танилцаж хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ тус тус байгуулж, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилга, хувийн дугаар, нийтийн тээврийн газраас ID код авсан байна.	Г
	1.2.Хэсгийн даргаас хуваарилж өгсөн автобусыг хувийн хэргээр хүлээн авч эзэмших, автобусны өнгө үзэмж, цэвэрлэгээ, ашиглалт, сэлбэг, шатахууны зарцуулалт, дугуйны бүрэн бүтэн байдал, смарт картны тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг бүрэн хариуцах ба ажил амралтын хуваарийн дагуу ажиллаж,амрах	Хэсгийн даргаас хуваарилж өгсөн автобусыг хувийн хэргээр хүлээн авч эзэмшиж, автобусны өнгө үзэмж, цэвэрлэгээ, ашиглалт, сэлбэг, шатахууны зарцуулалт, дугуйны бүрэн бүтэн байдал, смарт картны тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, ажил амралтын хуваарийн дагуу ажиллаж,амарна.	Г
	1.3.Жолооч нь ажилд гарахын өмнө смарт картны тоног төхөөрөмжийн ажиллагааг тогтмол шалгах, шугамын үйлчилгээнд ажиллаж байхдаа байнгын асаалттай байлгах, ямар нэгэн саатал гарвал нэн даруй Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчид мэдээллэх, Улаанбаатар смарт карт ХХК-тай холбоо барьж яаралтай дуудлага өгч засварлуулж хэвийн ажиллагааг хангах	Жолооч нь ажилд гарахын өмнө смарт картны тоног төхөөрөмжийн ажиллагааг тогтмол шалгаж, шугамын үйлчилгээнд ажиллаж байхдаа байнгын асаалттай байлгаж, ямар нэгэн саатал гарвал нэн даруй Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчид мэдээлж, Улаанбаатар смарт карт ХХК-тай холбоо барьж	Г

		яаралтай дуудлага өгч засварлуулж, хэвийн ажиллагааг хангасан байна.	
	1.4.Жолооч нь зорчигчдыг тээврийн хэрэгслийн орох хаалгаар оруулах, гарах хаалгаар буулгах үйлчилгээг соёлтой боловсон хөнгөн шуурхай хүргэх, зорчигчийг буудлын бус газар буулгах, суулгахыг хатуу хориглох	Жолооч нь зорчигчдыг тээврийн хэрэгслийн орох хаалгаар оруулж, гарах хаалгаар буулгаж үйлчилгээг соёлтой боловсон хөнгөн шуурхай хүргэж, зорчигчийг буудлын бус газар буулгаж, суулгахгүй ажилласан байна.	Г
	1.5.Жолооч нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, үйлчилгээний талаар санал, гомдлын зөрчилгүй ажиллах, Тбох-н болон шугам цагийн алдагдалгүй, нийтийн тээврийн MNS 5012:2011 стандартыг чанд мөрдөх, хэрэгжүүлж ажиллах	Жолооч нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, үйлчилгээний талаар санал, гомдол зөрчилгүй ажиллаж, Тбох-н болон шугам цагийн алдагдалгүй, нийтийн тээврийн MNS 5012:2011 стандартыг мөрдөж ажилласан байна.	Г
	1.6.Жолооч нь зорчигчдын төлбөр төлөлтөд хяналт тавих	Жолооч нь зорчигчдын төлбөр төлөлтөд хяналт тавьж ажиллана.	Г
	1.7.Зорчигч нь бусдын тусгай картаар зорчсон тохиолдолд жолооч хурааж авах эрхтэй ба хураан авсан картыг хэсгийн даргад хүлээлгэн өгөх	Зорчигч нь бусдын тусгай картаар зорчсон тохиолдолд жолооч хурааж авах эрхтэй ба хураан авсан картыг хэсгийн даргад хүлээлгэж өгсөн байна.	Г
	1.8.Автобусны хяналтын камерын байрлал, тохиргоо, ажиллагаа, тусгалыг хөдөлгөж хөндөхгүй, унтраахгүй, халхлахгүй, хэвийн ажиллагааг хангаж ажиллах	Автобусны хяналтын камерын байрлал, тохиргоо, ажиллагаа, тусгалыг хөдөлгөж хөндөхгүй, унтраахгүй, халхлахгүй, хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна.	Г
	1.9.Смарт картын төхөөрөмжид үйлчлэх чиглэлийг сонгох, рейс тутамд жолоочийн ID кодыг оруулах	Смарт картын төхөөрөмжид үйлчлэх чиглэлийг сонгож, рейс тутамд жолоочийн ID кодыг оруулж ажиллана.	Г

	<p>1.10.Ажлаа дуусаад дулаан зогсоолд тэргээ тавихдаа төхөөрөмжийг бүрэн унтраах (тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг шалгаж ямар нэгэн саатал гарвал Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэх, смарт картны засварын төвд хандах), өглөө нэг бүрчлэн асаах, ажиллагааг шалгаж гарах, бусад тохиолдолд төхөөрөмжийг унтраахгүй байх (цайны цаг гэх мэт)</p>	<p>Ажлаа дуусаад дулаан зогсоолд тэргээ тавихдаа төхөөрөмжийг бүрэн унтрааж, өглөө нэг бүрчлэн асааж, ажиллагааг шалгаж гарах, бусад тохиолдолд төхөөрөмжийг унтраахгүй байна. Ямар нэгэн доголдол гарсан тохиолдолд Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдсэн байна.</p>	Г
	<p>1.11.Тухайн чиглэлийн батлагдсан цаг, график, замналын дагуу үйлчилгээг үзүүлэх (өглөөний эх авалт, оройн буулт, графикт заагдсан цагт, цайны цаг хэтрүүлэхгүй, эцсийн буудлууд дээр шалтгаангүй удаан зогсохгүй)</p>	<p>Тухайн чиглэлийн батлагдсан цаг, график, замналын дагуу нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлсэн байна.</p>	Г
	<p>1.12.Замын нөхцөл, хөдөлгөөний нягтралд хурдаа тохируулах, хоорондын зайг барьж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, батлагдсан замнал, хөдөлгөөний цагийн хуваарийг чанд мөрдөн үйлчлэх, буудал зарлагчийг бүрэн ажиллуулах, автобусны буудал зогсоолын (карма) талбайд автобусыг бүрэн оруулж зогсож, зорчигчдыг бүрэн буулгаж, суулгасны дараа хаалгаа хааж хөдлөх</p>	<p>Замын нөхцөл, хөдөлгөөний нягтралд хурдаа тохируулж, хоорондын зайг барьж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, батлагдсан замнал, хөдөлгөөний цагийн хуваарийг чанд мөрдөн үйлчилж, буудал зарлагчийг бүрэн ажиллуулж, автобусны буудал зогсоолын (карма) талбайд автобусыг бүрэн оруулж зогсож, зорчигчдыг бүрэн буулгаж, суулгасны дараа хаалгаа хааж хөдөлнө.</p>	Г
	<p>1.13.Байгууллагаас эзэмшүүлсэн эд хөрөнгийг зориулалтын дагуу хайр гамтай эзэмшин бүрэн бүтэн хүлээлгэж өгөх</p>	<p>Байгууллагаас эзэмшүүлсэн эд хөрөнгийг зориулалтын дагуу эзэмшиж, бүрэн бүтэн хүлээлгэж өгнө.</p>	Г

<p>1.14.Ажилд гарахдаа стандартын шаардлагын дагуу автобусны дотор гадна цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хийх, чиглэлийн хаяг нэрийн хуудас, гаралтын дугаарыг зохих газарт нь байрлуулах, ажлын хувцасыг өмсөх, бичиг баримтын зөрчилгүй байх</p>	<p>Ажилд гарахдаа стандартын шаардлагын дагуу автобусны дотор гадна цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хийж, чиглэлийн хаяг нэрийн хуудас, гаралтын дугаарыг зохих газарт нь байрлуулж, ажлын хувцасыг өмсөж, бичиг баримтын зөрчилгүй байна.</p>	Г
<p>1.15.Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлөөс үүссэн торгуулийг цаг тухайд нь барагдуулах.</p>	<p>Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлөөс үүссэн торгуулийг цаг тухайд нь барагдуулсан байна.</p>	Г
<p>1.16.Жолооч нь заалны аюулгүй ажиллагааг бүрэн хангах, зорчигчдыг зориулалтын бариулаас барих, сандалд сууж аюулгүй байдлаа хангаж үйлчлүүлэх талаар анхааруулга зөвлөмжийг өгч ажиллах</p>	<p>Жолооч нь заалны аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, зорчигчдыг зориулалтын бариулаас барьж, сандалд сууж аюулгүй байдлаа хангаж үйлчлүүлэх талаар анхааруулга зөвлөмжийг өгч ажилласан байна.</p>	Г
<p>1.17.Жолоочийн буруутай үйл ажиллагаанаас болж төхөөрөмж эвдэрч гэмтсэн бол засвар үйлчилгээний зардлыг бүрэн хариуцах</p>	<p>Жолоочийн буруутай үйл ажиллагаанаас болж төхөөрөмж эвдэрч гэмтсэн бол засвар үйлчилгээний зардлыг бүрэн хариуцна.</p>	Г
<p>1.18.Өглөө ажилчдын "А" жижүүрийн унаагаар байгууллага дээр ирж, (оройн ээлжинд ажиллах жолооч НТБГ-ын баталсан цаг графикийн хуваарьт заасан цэг буудлаас ажилдаа гарна) тэрэг тавигчаас тээврийн хэрэгслээ хүлээн авах, техникийн ерөнхий үзлэг хийх, шалгах хуудас бөглөх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолооны болон мэргэшсэн үнэмлэхээ шалгах механикт шалгуулах, шалгах механикийн зөвшөөрлийн дагуу Тээвэр, хөдлгөөн зохицуулагчид шалгах хуудсаа өгч замын хуудас авах, хуваарилсан чиглэлд нийтийн тээврийн стандарт мөрдөж ажиллах</p>	<p>Өглөө ажилчдын "А" жижүүрийн унаагаар байгууллага дээр ирж, (оройн ээлжинд ажиллах жолооч НТБГ-ын баталсан цаг графикийн хуваарьт заасан цэг буудлаас ажилдаа гарна) тэрэг тавигчаас хэрэгслээ хүлээн авч, техникийн ерөнхий үзлэг хийж шалгах хуудас бөглөж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолооны болон мэргэшсэн үнэмлэхээ шалгах механикт шалгуулж, шалгах механикийн зөвшөөрлийн дагуу Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчид шалгах</p>	Г

		хуудсаа өгч замын хуудас авч, хуваарилсан чиглэлд нийтийн тээврийн стандарт мөрдөж ажиллана.	
1.19.Өдөр ээлж солилцох үед өглөөний ээлжийн жолооч оройн ээлжинд гарахаар ирсэн жолоочийн биеийн байдал, жолоодох эрхийн болон мэргэшсэн үнэмлэхийг шалгах, тээврийн хэрэгслийг ерөнхий үзлэгээр хүлээлгэн өгөх	Өдөр ээлж солилцох үед өглөөний ээлжийн жолооч оройн ээлжинд гарахаар ирсэн жолоочийн биеийн байдал, жолоодох эрхийн болон мэргэшсэн үнэмлэхийг шалгаж тээврийн хэрэгслийг ерөнхий үзлэгээр хүлээлгэн өгнө.	Г,Х	
1.20.Ажлаас буухдаа эцсийн буудлаас замналын дагуу байгууллагад ирэх, техникийн бэлэн байдлыг Шалгах механикт шалгуулах, Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчаар цаг, рейс саатлаа бичүүлэн замын хуудсаа хаалгах, Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчийн цохолтоор шатахуун түгээх станцаас дараа өдрийн шатахуунаа авах, заалаа угааж цэвэрлээд, хогийг хогийн саванд асгаж, тээврийн хэрэгслийг дулаан зогсоолд галын аюулгүйн дүрмийн дагуу байрлуулах, тогоо салган, Тэрэг тавигчид түлхүүрийн хамт хүлээлгэн өгөх	Ажлаас буухдаа эцсийн буудлаас замналын дагуу байгууллагад ирж, техникийн бэлэн байдлыг Шалгах механик шалгуулж, Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчаар цаг, рейс саатлаа бичүүлэн замын хуудсаа хаалгаж, Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчийн цохолтоор шатахуун түгээх станцаас дараа өдрийн шатахуунаа авч, заалаа угааж цэвэрлээд, хогийг хогийн саванд асгаж, тээврийн хэрэгслийг дулаан зогсоолд галын аюулгүйн дүрмийн дагуу байрлуулж, тогоо салган, Тэрэг тавигчид түлхүүрийн хамт хүлээлгэн өгнө.	Г	
1.21.Тээврийн хэрэгсэл засвартай буюу бэлтгэл хуваарьт тавигдсан бол Тээвэр, хөдөлгөөн зохицуулагч, Хэсгийн дарга, Засварын инженерт бүртгүүлэх, даалгасан ажлыг хийж бэлтгэл цаг авнах, сард 1-2 удаа ажилчдын "А" жижүүрийн үйлчилгээнд гарч ажиллах,	Тээврийн хэрэгсэл засвартай буюу бэлтгэл хуваарьт тавигдсан бол Тээвэр, хөдөлгөөн зохицуулагч, Хэсгийн дарга, Засварын инженерт бүртгүүлж, даалгасан ажлыг хийж бэлтгэл цаг авна. Сард 1-2 удаа ажилчдын "А"	Г	

<p>байгууллага дээр хонох, гачигдалтай бол чөлөө хүссэн өргөдлөө бичгээр гаргаж, захиргаанд өгч шийдвэрлүүлнэх, өвдсөн бол хэсгийн даргад яаралтай мэдэгдэж эмчийн магадлагааг хүргүүлэн, ажлын хуваарьт зохицуулалт хийлгэх, эмнэлгийн чөлөөний хугацаа дуусч ажилдаа орохдоо, эмнэлгийн листийг Хүний нөөцийн ажилтнар ормон эсэхийг шалгуулан хоногийн тулгалт хийсний дараа ажилд гарах</p>	<p>жижүүрийн үйлчилгээнд гарч ажиллаж, байгууллага дээр хононо. Гачигдалтай бол чөлөө хүссэн өргөдлөө бичгээр гаргаж, захиргаанд өгч шийдвэрлүүлнэ. Өвдсөн бол хэсгийн даргад яаралтай мэдэгдэж эмчийн магадлагааг хүргүүлэн, ажлын хуваарьт зохицуулалт хийлгэнэ. Эмнэлгийн чөлөөний хугацаа дуусч ажилдаа орохдоо, эмнэлгийн лист бичгдэж ирсэн эсэхийг шалгуулж, хоногийн тулгалт хийсний дараа ажилд гарна.</p>	
<p>1.22.Санал хүсэлтээ хэсгийн дарга болон холбогдох ажилтанд тавьж шийдвэрлүүлэх</p>	<p>Санал хүсэлтээ хэсгийн дарга болон холбогдох ажилтанд тавьж шийдвэрлүүлнэ.</p>	Г
<p>1.23.Тээврийн хэрэгсэл шугам замд эвдэрсэн үед Тээвэр, хөдөлгөөн зохицуулагч, Засварын инженер, Хэсгийн даргад мэдэгдэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замыг чөлөөлж зогсох ба чирэгч автомашин ирсэн үед аюулгүй ажиллагааг ханган чирүүлж, байгууллага дээр ирж засварт оруулах</p>	<p>Тээврийн хэрэгсэл шугам замд эвдэрсэн үед Тээвэр, хөдөлгөөн зохицуулагч, Засварын инженер, Хэсгийн даргад мэдэгдэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж замыг чөлөөлж зогсох ба чирэгч автомашин ирсэн үед аюулгүй ажиллагааг ханган чирүүлж, байгууллага дээр ирж засварт оруулна.</p>	Г
<p>1.24.Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хурдаа тохируулан зөвхөн нэгдүгээр эгнээгээр зорчих</p>	<p>Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хурдаа тохируулан зөвхөн нэгдүгээр эгнээгээр зорчино.</p>	Г
<p>1.25.Жолооч цахим төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаарх зөвлөмжтэй танилцах, зөвлөмжийг мөрдөж ажиллах ба зөвлөмжөөс ойлгоогүй зүйлийг Хэсгийн дарга, Тээвэр,</p>	<p>Жолооч цахим төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаарх зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийг мөрдөж ажиллана. Зөвлөмжөөс</p>	Г

	хөдөлгөөн зохицуулагчаас тодруулга авах	ойлгоогүй зүйлээ Хэсгийн дарга, Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчаас тодруулна.	
	1.26.Жолооч урсгал засвар болон техникийн ТҮ-1,ТҮ-2-ийн үйлчилгээнд орохдоо засварын хуудсыг Шалгах механикаас авах, Засварын инженерт бүртгүүлэн шаардлагатай хийх засварыг хэлж оношлуулах, засварлуулж засвар дууссаны дараа тээврийн хэрэгслээ хүлээн авч шалгах механикт шалгуулах, шугаманд гарах буюу шугамын гаралт байхгүй бол Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрлөөр тэрэг тавигчид тээврийн хэрэгслийг хүлээлгэн өгч, зогсоолд байрлуулах	Жолооч урсгал засвар болон техникийн ТҮ-1,ТҮ-2-ийн үйлчилгээнд орохдоо засварын хуудсыг Шалгах механикаас авч, Засварын инженерт бүртгүүлэн шаардлагатай хийх засварыг хэлж оношлуулан, засварлуулж засвар дууссаны дараа тээврийн хэрэгслийг хүлээн авч шалгах механикт шалгуулж, шугаманд гарах буюу шугамын гаралт байхгүй бол Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрлөөр тэрэг тавигчид тээврийн хэрэгслийг хүлээлгэн өгч, зогсоолд байрлуулсны дараа амарч болно.	Г
	1.27.Засвар үйлчилгээ хийх үед засварын суваг болон хүлээх талбайд тээврийн хэрэгсэлээ эзэнгүй орхиж явахгүй байх	Засвар үйлчилгээ хийх үед засварын суваг болон хүлээх талбайд тээврийн хэрэгсэлээ эзэнгүй орхиж явахыг хориглоно.	Г
	1.28.Автобусны хяналтын камерыг санаатай болон санамсаргүй унтраах, салгах, эргүүлэх, халхлах, тээврийн хэрэгслийн тогийг засварт орох буюу гараашид байрлуулахаас бусад тохиолдолд салгахгүй байх	Автобусны хяналтын камерыг санаатай болон санамсаргүй унтраах, салгах, эргүүлэх, халхлах, тээврийн хэрэгслийн тогийг засварт орох буюу гараашид байрлуулахаас бусад тохиолдолд салгахыг хориглоно.	Г
2 дугаар зорилтын хүрээнд:	2.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөж ажилласан байна.	Г

2.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байна.	Г
2.3.Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах	Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авсан байна.	Г
2.4.Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орсон байна.	Г
2.5.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэсэн байна.	Г
2.6.Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх	Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй ажилласан байна.	Г
2.7.Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлсэн байна.	Г

III.АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн бус дунд түүнээс дээш	
Мэргэжил	Жолоочийн Д ангилалтай,	
Мэргэшил	21-ээс дээш насны Д ангиллын мэргэшсэн жолооч байх	
Туршлага	Жолоочоор 5 ба түүнээс дээш жил ажилласан, Нийтийн тээвэрт явж байсан бол давуу тал болох	
Ур чадвар	Чухал шаардлагатай	Харилцааны соёлтой Жолоодох ур чадвар сайтай байх
	Шаардлагатай	Багаар ажиллах Хүнтэй ажиллах ур чадвартай, зөв боловсон харьцаатай байх

IV. АЖЛЫН БАЙРНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн дарга, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн Ахлах инженер

Ажлын байранд шууд харьяалан удирдуулах ажлын байрны нэр, тоо:

- 1. Нийтийн тээврийн бодлогын газар
- 2. Улаанбаатар смарт карт ХХК

V. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: "ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
..... П.АЛТАНТӨГС

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 07 дугаар сарын 23-ны өдөр

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: "ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ

Шийдвэрийн огноо: 2025.07.23

Дугаар А/52

(тамга/тэмдэг)

ДАРГА: О.ГАНБААТАР



(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 07 дугаар сарын 23-ны өдөр